

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 04-р сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

“БиДиСек ҮЦК” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 10 цаг 00 минутад компанийн байранд цахим хэлбэрээр/онлайнаар явагдаж эхлэв.

“БиДиСЕК ҮЦК” ХК нь гаргасан нийт 13,694,883 ширхэг энгийн хувьцаатай ба үүнээс саналын эрхгүй хувьцаа байхгүй болно.

“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нийт саналын эрхтэй хувьцааны 66.70% буюу 9,134,458 ширхэг хувьцаа эзэмшиж буй 31 хувьцаа эзэмшигч оролцов. Үүнээс 1,595,879 ширхэг хувьцаа эзэмшиж буй 5 хувьцаа эзэмшигч ҮЦК-иар дамжуулан, 990 ширхэг хувьцаа эзэмшиж буй 6 хувьцаа эзэмшигч цахимаар, 7,537,589 ширхэг хувьцаа эзэмшиж буй 20 хувьцаа эзэмшигч саналаа ирүүлж хурлын ирцээ баталгаажуулан оролцов.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц 66.70%-иар хүчин төгөлдөр болсноор “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн хурлын дарга Бүрэнмэнд овогтой Лхагвадорж хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээв. Хэлэлцэх асуудал 1-ийг компанийн Гүйцэтгэх захирал Д.Даянбилгүүн, Нягтлан бодогч Т.Шүүдэрцэцэг, бусад хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг хурлын дарга Б.Лхагвадорж танилцууллаа.

Өөрийн биеэр ирж ирцийн баталгаажуулалт хийж, саналын хуудсаар саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчид:

- ҮЦК-иар дамжуулан саналын хуудсаар хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо	Хувь	Төрөл
1	Naoto Sumiyoshi	60,540	0.44%	саналын хуудсаар
2	Daniel Paul Stein	258,874	1.89%	саналын хуудсаар
3	Reda Maamari	418,576	3.06%	саналын хуудсаар
4	Impera Mongolia Holding LTD	855,941	6.25%	саналын хуудсаар
5	Jacobus Hendrik Joseph Thelen	1,948	0.01%	саналын хуудсаар
	Нийт	1,595,879	11.65%	

- Хувьцаа эзэмшигчдийн хуралд саналаа цахим саналаар өгсөн хувьцаа эзэмшигчид:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо	Хувь	Төрөл
1	С.Дамдинсүрэн	118	0.00%	Онлайнаар
2	Т. Сүлдэр	351	0.00%	Онлайнаар
3	О. Хотул	1	0.00%	Онлайнаар
4	Р. Бас-Ерөөл	500	0.00%	Онлайнаар
5	Ц. Мөнх-Эрдэнэ	16	0.00%	Онлайнаар
6	А. Марал	4	0.00%	Онлайнаар
	Нийт	43,637	0.32%	

- Компанийн байранд өөрийн биеэр ирж ирцээ баталгаажуулан хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын хуудсаа өөрийн биеэр авчирч өгсөн хувьцаа эзэмшигчид:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо	Хувь	Төрөл
1	Д.Даянбилгүүн	2,377,150	17.36%	саналын хуудсаар
2	Д.Амгаланбаяр	332,129	2.43%	саналын хуудсаар
3	Монголиан Мастер Менежмент	1,201,425	8.77%	саналын хуудсаар
4	Ш.Шинэбаяр	2,580	0.02%	саналын хуудсаар

5	С.Пүрэвсүрэн	3,732	0.03%	саналын хуудсаар
6	Д.Тэнүүн	8,457	0.06%	саналын хуудсаар
7	Д.Ихтөгөлдөр	10,193	0.07%	саналын хуудсаар
8	Тасган Инвест ХХК	2,090,603	15.27%	саналын хуудсаар
9	Б.Энхбаяр	100	0.00%	саналын хуудсаар
10	Санаа-Эгээ ХХК	309,091	2.26%	саналын хуудсаар
11	Д.Эрдэнэчимэг	14,352	0.10%	саналын хуудсаар
12	Н.Батгэрэл	328,014	2.40%	саналын хуудсаар
13	Эм И Ти Эф	369,238	2.70%	саналын хуудсаар
14	О. Уранбайгал	881	0.01%	саналын хуудсаар
15	Д. Дайчинбаатар	12,999	0.09%	саналын хуудсаар
16	Б. Лхагвадорж	465,436	3.40%	саналын хуудсаар
17	Д. Хөхлэй	6,067	0.04%	саналын хуудсаар
18	Г. Хосбаяр	41	0.00%	саналын хуудсаар
19	А. Зориг	2,100	0.02%	саналын хуудсаар
20	Б. Энхбаяр	3,001	0.02%	саналын хуудсаар
Нийт		7,537,589	54.96%	

Хурлаар хэлэлцсэн асуудлуудын жагсаалт:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан, аудитлагдсан санхүүгийн тайланг хэлэлцэж, түүнд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах;
2. Ногдол ашиг тараах тухай шийдвэрийг танилцуулах;
3. ТУЗ-ийн 2022 оны төсөв батлах;
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох.

Саналын хуудсаар дараах шийдвэр гарав:

Тооллогын комисс нь нийт 9,130,472 ширхэг хувьцаатай 26 хувьцаа эзэмшигчийн саналыг хуудсыг онлайнаар болон хэвлэмлээр хүлээн авсан. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдээс 5 ширхэг хувьцаа эзэмшиж буй 2 хувьцаа эзэмшигч онлайнаар, 9,130,467 ширхэг хувьцаа эзэмшиж буй 24 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар дамжуулан санал урьдчилж санал өгсөн.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдээс 3,986 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа 5 хувьцаа эзэмшигч санал ирүүлээгүй байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд дараах асуудлуудад хувьцаа эзэмшигчид **ердийн аргаар** санал өгөх байв. Үүнд:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны төсөв батлах

Дээрх асуудлуудад хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн саналын хуудсыг тоолох явцад 9,130,472 ширхэг хувьцаатай 26 хувьцаа эзэмшигчийн саналын хуудас хүчин төгөлдөр, 3,986 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа 5 хувьцаа эзэмшигч санал ирүүлээгүй, хүчингүй саналын хуудас байгаагүй болно.

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, аудитлагдсан санхүүгийн тайланг хэлэлцэж, түүнд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.96% буюу 9,130,472 ширхэг хувьцаатай 26 хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0.00% татгалзсан, 0.00% түдгэлзсэн байна.

2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны төсөв батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.96% буюу 9,130,472 ширхэг хувьцаатай 26 хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн **100% зөвшөөрсөн, 0.00% татгалзсан, 0.00% түдгэлзсэн** байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд дараах асуудалд хувьцаа эзэмшигчид **кумулятив аргаар** санал өгөх байв. Үүнд:

3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

Уг хэлэлцсэн асуудалд хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн саналын хуудсыг тоолох явцад нийт 8,649,404 ширхэг хувьцаатай 22 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудас хүчинтэй, 483,102 ширхэг хувьцаатай 7 хувьцаа эзэмшигч санал ирүүлээгүй, 1,952 ширхэг хувьцаатай 2 хувьцаа эзэмшигчийн саналын хуудас хүчингүй байсан.

Хувьцаа эзэмшигчид дараах асуудалд кумулятив аргаар санал өгөв:

ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдэд өгсөн санал:

Ердийн гишүүдэд:

	Нэр	Саналын хувь
1	Д.Даянбилгүүн	12.68%
2	Б.Лхагвадорж	9.68%
3	Н.Батгэрэл	9.68%
4	Улуч Бингол	19.57%
5	О.Уранбайгал	9.68%

Хараат бус гишүүдэд:

	Нэр	Саналын хувь
1	Хитоши Тани	9.68%
2	Д.Амгаланбаяр	9.68%
3	Б.Энхбаяр	9.68%
4	Б.Амарсанаа	0%
5	Д.Энхжаргал	0%
6	О.Лхагвасүрэн	9.68%

тус тус санал авч,

Ердийн гишүүдэд:

1. Д.Даянбилгүүн
2. Б.Лхагвадорж
3. Н.Батгэрэл
4. Улуч Бингол
5. О.Уранбайгал

Хараат бус гишүүдэд:

1. Хитоши Тани
2. Б.Энхбаяр
3. Д.Амгаланбаяр
6. О.Лхагвасүрэн нар тус тус сонгогдов.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоолын шийдвэрийг 11 цаг 25 минутанд танилцуулан дуусч, хурлын дарга хурлыг хаав. Хувьцаа эзэмшигчид хэрхэн өөрийгөө баталгаажуулж хуралд оролцсон, хуралд санал өгсөн болон хурлын бичлэгийг хадгалсан болно.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

/Э.Эрхэмзаяа/

Хурлын дарга:

/Б.Лхагвадорж/

